

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.4. Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийг шуурхай, бүрэн олгох, өвөлжилтийн бэлтгэл хангах, агаарын бохирдлыг бууруулах, салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хуулийн дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгох, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг 2017 онд бүрэн олгож дуусгах ажлыг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.

2. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа 9 төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбогдох аудитын дүгнэлтийг гаргаж, санал, дүгнэлтийг Сангийн яаманд яаралтай хүргүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний аудитын газарт зөвлөмж болгож, батлагдсан эх үүсвэрийг 2017 онд багтаан олгох ажлыг шуурхай зохион байгуулахыг Үндэсний хөгжлийн газарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР